


ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬ-2020

**ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
ДАВААДОРЖИЙН
ЛХАГВАСҮРЭНГИЙН
ДЭВШҮҮЛЖ БУЙ
МӨРИЙН ХӨТӨЛБӨР**



2020.07.21.

ХӨВСГӨЛ АЙМАГ

Handwritten signature and date: 3.2020

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ДАВААДОРЖ ОВОГТОЙ ЛХАГВАСҮРЭНГИЙН
СОНГУУЛИЙН МӨРИЙН ХӨТӨЛБӨР

2020.07.21

Мөрөн хот

Нэр дэвшигч сонгуулийн мөрийн хөтөлбөрийг боловсруулахдаа УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, мөн 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, 2001 оны 57 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”, Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2015 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Хөвсгөл аймгийн нийгэм, эдийн засгийг 2016-2030 онд хөгжүүлэх урт хугацааны хөтөлбөр” зэрэг баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилго, зорилтын хүрээнд тулгуурлан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль болон мөн хуулийн 37 дугаар зүйлийн хэсэгт нийцүүлэн боловсрууллаа.


“Иргэдийн амьдралыг сайжруулах”-д мөрийн хөтөлбөрийн зорилго оршино. Дээрх зорилгын хэрэгжүүлэхээр дараах зорилтуудыг хэрэгжүүлнэ.

1. Төсөв, мөнгө, боловсон хүчний болон эд хөрөнгөний эрх мэдлийг бодитой шилжүүлэх замаар нутгийн өөрөө удирдах байгууллагын бие даасан байдлыг хангана.
2. Нийгмийн үйлчилгээг чанартай, хүртээмжтэй хувь хүн, гэр бүлийн хөгжлийг бүрэн дэмжсэн байх зарчимд тулгуурласан бодлого хэрэгжүүлнэ.
3. Кластерийг бүсчлэн хөгжүүлэх Нэг аймаг нэг салбар, нэг сум нэг бүтээгдэхүүнийг брэнд болгож хөгжүүлэхэд анхаарна.
4. Мөрөн хотын утаа, хогны менежментийг сайжруулах бодлого хэрэгжүүлнэ
5. Импортоор оруулдаг хүнсний бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэдэг болж, төмс, хүнсний ногоо, сүү, өндөгний хэрэгцээг дотооддоо хангадаг бодлогыг баримтална.
6. Усалгаатай газар тариаланг сэргээж дэмжих бодлого баримтална.
7. Барилгын материалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах бодлого баримтална.
8. Ажлын байр нэмэгдүүлсэн, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ажил олгосон аж ахуйн нэгж болон ажлын байрандаа олон жил тогтвор суурьшилтай ажилласан иргэдийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөр санаачилна.

17144193
062 907060

9. Иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулж, мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг ажлын байртай шууд холбон тогтвортой ажил, хөдөлмөр эрхлэх боломжийг бий болгох бодлого баримталж ажиллана.


БОЛОВСРУУЛСАН:



Д.ЛХАГВАСҮРЭН

/БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ/
Хаяг: Хөвсгөл аймаг, Мөрөн
сум, 14-р баг 13-08 тоот
Регистрийн дугаар:
РЮ84092670
Холбоо барих: 96191717
Мэйл:
Lhagvaa8888@gmail.com



 3.24
7000003